



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон-Чулуут голын сав газрын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2023/72/-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Архангай аймаг

2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа

Утас: 7033-3141

Цахим хаяг: [Baigalmaat@audit.gov.mn](mailto:Baigalmaat@audit.gov.mn)

Аудитын менежер Д.Нэргүйбаатар

Утас: 7033-2860

Цахим хаяг: [Nerguibaatar@audit.gov.mn](mailto:Nerguibaatar@audit.gov.mn)

Аудитор Н.Энхчимэг

Утас: 7033-3019

Цахим хаяг: [Enkhchimegn@audit.gov.mn](mailto:Enkhchimegn@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

<u>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</u> ...	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</u>	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<b>Bookmark not defined.</b>	
<u>3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>3.5.3 Нэмэлт төсөв</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>4. АУДИТЫН ТАЙЛАН</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>4.1 Ерөнхий зүйл</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>4.2 Материаллаг байдал</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<b>Bookmark not defined.</b>	
<u>4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт</u> ...	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>5.1 Төлбөрийн акт</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>5.2 Албан шаардлага</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>5.3 Зөвлөмж</u> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<u>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</u>	<b>Error! Bookmark not defined.</b>

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЕА	Монгол улсын ерөнхий аудитор

УСНББОУС

Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг  
Утас/Факс: 976-70333141  
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2023.02.13 № 30

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон чулуут голын сав газрын захиргааны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага нь "Усны засаглалыг шинэлэг арга замаар сайжруулах нь" төслийн хүрээнд Архангай аймгийн Эрдэнэбулган сумын Ар-Ус Ундарга ХХК, Өвөрхангай аймгийн Хархорин сумын Хархорин Ус суваг ХХК, Хужирт сумын Хан-Хужирт, Хужирт рашаан сувилал ХХК-ийн цэвэрлэх байгууламжийн хаягдал усны гаргалгааны шугамд /задгай сувгийн хэт авианы урсац хэмжигч/ тоолуурыг суурилуулсан. Уг тоолуур нь БНХАУ-ын Sichuan Hongjun Science Tehnology үйлдвэрлэсэн HUP350 маркын 90м³/цаг хүртэл хэмжих хүчин чадалтай. Энэхүү тоолуур нь усыг лазераар эзэлхүүн мэдэрдэг бөгөөд өмнө нь Монголд суурилуулж байгаагүй онцлогтой.

#### Аудитын гол асуудал

Тус байгууллага нь БОАЖЯ-ны сайдын 2018 оны батлагдсан орон тоогоор ажиллаж байгаа. Орон тооны 12 ажилтан. Үүнээс төрийн захиргааны 10, үйлчилгээний 2 ажилтантай.

#### **Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 16 зорилтын хүрээнд 36 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг БОАЖ-ын сайдын үнэлгээр 91,5 хувьтай үнэлсэн байна .

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>13,027,880.00</b>	<b>3,651,000.00</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>13,027,880.00</b>	<b>3,651,000.00</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>13,027,880.00</b>	<b>3,651,000.00</b>
35420	Аж ахуйн материал	13,027,880.00	3,651,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>354,092,212.33</b>	<b>330,518,007.14</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>354,092,212.33</b>	<b>330,518,007.14</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>324,092,212.33</b>	<b>300,518,007.14</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	124,679,637.00	124,679,637.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-9,569,349.15	-9,569,349.15
39203	Авто-тээврийн хэрэгсэл	53,800,000.00	48,220,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-1,674,000.00	-5,506,333.30
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	232,696,341.53	199,997,471.51
39206	Хуримтлагдсан элэгдэл	-80,675,861.84	-60,456,051.90
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,665,787.65	19,791,331.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	-25,830,342.86	-16,638,698.42
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>30,000,000.00</b>	<b>30,000,000.00</b>
39301	Програм хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-770,000.00	-770,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	30,000,000.00	30,000,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>367,120,092.33</b>	<b>334,169,007.14</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>367,120,092.33</b>	<b>334,169,007.14</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>367,120,092.33</b>	<b>334,169,007.14</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	30,000,000.00	30,000,000.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	30,000,000.00	30,000,000.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>337,120,092.33</b>	<b>304,169,007.14</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	289,080,155.14	337,120,092.33
51220	Тайлант үеийн үр дүн	48,039,937.19	-32,951,085.19
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>367,120,092.33</b>	<b>334,169,007.14</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
-----	----------	----------	------------

<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>304,259,837.00</b>	<b>234,010,900.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>52,617,637.00</b>	<b>2,167,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>52,617,637.00</b>	<b>2,167,000.00</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	52,617,637.00	2,167,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>251,642,200.00</b>	<b>231,843,900.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>243,142,200.00</b>	<b>224,911,400.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	243,142,200.00	224,911,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>8,500,000.00</b>	<b>6,932,500.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	6,932,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,500,000.00	0.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>256,219,899.81</b>	<b>263,311,950.47</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>256,219,899.81</b>	<b>263,311,950.47</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>224,327,150.74</b>	<b>252,010,729.47</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>133,997,346.93</b>	<b>144,033,872.49</b>
210101	Үндсэн цалин	102,589,245.03	112,962,274.70
210102	Нэмэгдэл	26,823,885.88	22,871,879.79
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,584,216.02	7,349,591.00
210104	Урамшуулал	0.00	850,127.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>18,366,200.00</b>	<b>17,977,099.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	13,210,939.54	12,224,074.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,288,813.97	1,438,255.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,031,211.15	1,173,124.62
210204	Ажилгүйдлийн даатгал	257,602.82	265,131.14
210205	Эрүүл мэндийн даатгал	2,577,632.52	2,876,513.48
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>14,009,800.00</b>	<b>15,310,356.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	0.00	798,758.00
210302	Түлш, халаалт	9,635,641.00	9,295,794.00
210303	Цэвэр, бохир ус	414,159.00	1,656,304.00
210304	Байрны түрээс	3,960,000.00	3,559,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>15,633,340.00</b>	<b>25,194,061.00</b>
210401	Бичиг хэрэг	3,321,770.00	2,530,440.00

Архангай аймгийн Орхон-Чулуут голын сав газрын азхиргааны 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210402	Тээвэр, шатахуун	9,303,990.00	8,492,969.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,066,370.00	1,372,080.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,941,210.00	12,798,572.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>0.00</b>	<b>337,100.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	337,100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>0.00</b>	<b>2,497,800.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	387,800.00
210604	Урсгал засвар	0.00	2,110,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>7,670,000.00</b>	<b>5,058,200.00</b>
210702	Дотоод албан томилолт	7,670,000.00	5,058,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>28,434,584.00</b>	<b>16,170,170.51</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,194,384.00	15,489,590.51
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	73,700.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	4,900.00	86,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	124,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	235,300.00	395,280.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>6,215,879.81</b>	<b>25,432,070.47</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	1,997,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,689,300.00	1,343,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	4,526,579.81	22,091,170.47
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>31,892,749.07</b>	<b>11,301,221.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>31,563,000.00</b>	<b>11,264,400.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,563,000.00	11,264,400.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>329,749.07</b>	<b>36,821.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	329,349.07	36,821.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	400.00	0.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>48,039,937.19</b>	<b>-29,301,050.47</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>3,650,034.72</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	3,650,034.72
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>48,039,937.19</b>	<b>-32,951,085.19</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>251,642,200.00</b>	<b>231,843,900.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>251,642,200.00</b>	<b>231,843,900.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>243,142,200.00</b>	<b>224,911,400.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	243,142,200.00	224,911,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>8,500,000.00</b>	<b>6,932,500.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	6,932,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,500,000.00	0.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>251,642,200.00</b>	<b>231,843,900.00</b>
299990	Устгал	0.00	0.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>251,642,200.00</b>	<b>231,843,900.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>219,749,450.93</b>	<b>220,542,679.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>136,043,350.93</b>	<b>144,552,900.00</b>
210101	Үндсэн цалин	102,271,649.03	111,565,500.00
210102	Нэмэгдэл	29,187,485.88	23,798,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,584,216.02	9,189,400.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>18,366,200.00</b>	<b>17,977,099.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	12,782,917.92	12,240,999.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,395,820.52	1,434,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,116,816.38	1,147,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	279,004.14	286,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,791,641.04	2,868,100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>14,009,800.00</b>	<b>15,358,221.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	52,599.00	846,623.00
210302	Түлш, халаалт	9,635,641.00	9,295,794.00
210303	Цэвэр, бохир ус	361,560.00	1,656,304.00
210304	Байрны түрээс	3,960,000.00	3,559,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>14,299,800.00</b>	<b>15,105,779.00</b>
210401	Бичиг хэрэг	2,626,960.00	2,100,500.00
210402	Тээвэр, шатахуун	9,166,900.00	7,992,969.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,312,140.00	1,612,610.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,193,800.00	3,399,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>641,500.00</b>	<b>515,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	641,500.00	515,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>356,400.00</b>	<b>2,409,600.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	356,400.00	299,600.00
210604	Урсгал засвар	0.00	2,110,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>7,670,000.00</b>	<b>5,058,200.00</b>
210702	Дотоод албан томилолт	7,670,000.00	5,058,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>25,873,100.00</b>	<b>15,556,280.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,632,900.00	15,065,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	83,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	4,900.00	73,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	124,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	235,300.00	209,380.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,489,300.00</b>	<b>4,009,600.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	2,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,489,300.00	2,009,600.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>31,892,749.07</b>	<b>11,301,221.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>31,563,000.00</b>	<b>11,264,400.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,563,000.00	11,264,400.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>329,749.07</b>	<b>36,821.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	329,349.07	36,821.00
213304	Хөрөнгийн	0.00	0.00
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын Оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн

1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	30,000,000.00	0.00	289,080,155.14	319,080,155.14
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	30,000,000.00	0.00	289,080,155.14	319,080,155.14
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	48,039,937.19	48,039,937.19
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	30,000,000.00	0.00	337,120,092.33	367,120,092.33
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	30,000,000.00	0.00	337,120,092.33	367,120,092.33
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	30,000,000.00	0.00	337,120,092.33	367,120,092.33
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-32,951,085.19	-32,951,085.19
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	30,000,000.00	0.00	304,169,007.14	334,169,007.14

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>224,911,400.00</b>	<b>224,874,579.00</b>	<b>36,821.00</b>	<b>99.98</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>224,911,400.00</b>	<b>224,874,579.00</b>	<b>36,821.00</b>	<b>99.98</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>213,647,000.00</b>	<b>213,610,179.00</b>	<b>36,821.00</b>	<b>99.98</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>144,589,000.00</b>	<b>144,552,900.00</b>	<b>36,100.00</b>	<b>99.98</b>
210101	Үндсэн цалин	111,565,500.00	111,565,500.00	0.00	100.00
210102	Нэмэгдэл	23,834,100.00	23,798,000.00	36,100.00	99.85
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,189,400.00	9,189,400.00	0.00	100.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>17,977,100.00</b>	<b>17,977,099.00</b>	<b>1.00</b>	<b>100.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	12,241,000.00	12,240,999.00	1.00	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,434,000.00	1,434,000.00	0.00	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,147,200.00	1,147,200.00	0.00	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	286,800.00	286,800.00	0.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,868,100.00	2,868,100.00	0.00	100.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>13,804,400.00</b>	<b>13,804,400.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	805,400.00	805,400.00	0.00	100.00
210302	Түлш, халаалт	8,229,100.00	8,229,100.00	0.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	1,590,400.00	1,590,400.00	0.00	100.00
210304	Байрны түрээс	3,179,500.00	3,179,500.00	0.00	100.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>12,486,100.00</b>	<b>12,486,100.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
210401	Бичиг хэрэг	1,300,500.00	1,300,500.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	6,989,000.00	6,989,000.00	0.00	100.00

Архангай аймгийн Орхон-Чулуут голын сав газрын азхиргааны 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,504,900.00	1,504,900.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,691,700.00	2,691,700.00	0.00	100.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>515,000.00</b>	<b>515,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	515,000.00	515,000.00	0.00	100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,409,600.00</b>	<b>2,409,600.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	299,600.00	299,600.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	2,110,000.00	2,110,000.00	0.00	100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,699,200.00</b>	<b>2,699,200.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,699,200.00	2,699,200.00	0.00	100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>15,157,000.00</b>	<b>15,156,280.00</b>	<b>720.00</b>	<b>100.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,665,700.00	14,665,700.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	83,200.00	83,200.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	73,200.00	73,200.00	0.00	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	124,800.00	124,800.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	210,100.00	209,380.00	720.00	99.66
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4,009,600.00</b>	<b>4,009,600.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,009,600.00	2,009,600.00	0.00	100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>11,264,400.00</b>	<b>11,264,400.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>11,264,400.00</b>	<b>11,264,400.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,264,400.00	11,264,400.00	0.00	100.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>224,911,400.00</b>	<b>224,911,400.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>224,911,400.00</b>	<b>224,911,400.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	224,911,400.00	224,911,400.00	0.00	100.00
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>25.00</b>	<b>25.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>12.00</b>	<b>12.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	1.00	1.00	0.00	100.00

65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>12.00</b>	<b>12.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	10.00	10.00	0.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	2.00	2.00	0.00	100.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		6,932,500.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		6,932,500.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		6,932,500.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>		1,553,731.00
210301	Гэрэл, цахилгаан		41,223.00
210302	Түлш, халаалт		1,066,604.00
210303	Цэвэр, бохир ус		65,904.00
210304	Байрны түрээс		380,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		2,619,679.00
210401	Бичиг хэрэг		800,000.00
210402	Тээвэр, шатахуун		1,003,969.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		107,710.00
210404	Ном, хэвлэл		708,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>		2,359,000.00
210702	Дотоод албан томилолт		2,359,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		400,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		400,000.00
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Усны тухай хуулийн 17-р зүйлийн 17,1-д үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлжээ. Орхон-Чулуут голын сав газрын захиргаа нь “Усны нөөц, баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, усны нөөцийн нэгдсэн менежментийг хэрэгжүүлэх, хүртээмжтэй эрүүл аюулгүй усаар хүн бүрийг хангах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах” гэсэн зорилт тавин ажиллажээ.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Орхон-Чулуут голын сав газрын захиргаа нь БОАЖЯ-ны харьяа байгууллага бөгөөд үйл ажиллагаагаа Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн хүрээнд явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль -2022.04.29
- “Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” ЗГ-ын 2022.05.25-ны 203 дугаар тогтоол
- “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” ЗГ-ын 2022.03.09-ны 107 дугаар тогтоол
- “Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 2022.05.11-ны 192 дугаар тогтоол
- “Тогтоол, тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” 2022.05.11-ны 194 дүгээр тогтоол

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант онд Дотоод аудитаас 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон-Чулуут голын сав газрын захиргааны 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/841 дугаар захирамжаар баталсан “Аймгийн ТЕЗ-ийн багцын харьяа төсөвт байгууллагуудад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” байна. Энэхүү баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Орхон-Чулуут голын сав газрын захиргааны 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан

бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн бөгөөд тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 32,951.1 мянган төгрөгөөр буюу 8.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Мянган төгрөгөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	13,027.8	3,651.0	(9,376.8)
Үндсэн хөрөнгө	354,092.2	330,518.0	(23,574.2)
<b>Нийт хөрөнгө</b>	367,120.1	334,169.0	(32,951.1)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	367,120.1	334,169.0	(32,951.1)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	367,120.1	334,169.0	(32,951.1)

Хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 9,376.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Аж ахуйн материалын дансанд 13,027.8 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 23,886.7 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 33,263.6 мянган төгрөг, акталж данснаас хассан 9,376.8 мянган төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 3,651.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна..

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 23,574.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь 354,092.2 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд Бусад эх үүсвэрээс 2,167.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан элэгдэл 92,940.4 мянган төгрөгөөр буурч, 330,518.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн буурсан нь тайлант хугацааны үр дүнг -32,951.1 мянган төгрөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 308456,1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 83544,7 мянган төгрөгийг бууруулан зардлыг 224911,4 мянган төгрөгөөр хянаж баталжээ.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 224911,4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 6932,5 зуун төгрөгийн нэмэлт санхүүжилтийг авсан байна.

. Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 199,294.7 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байгаа нь хангамж, бараа материалын зардлаас 36.8 мянган төгрөгийг хэмнэж буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл мянган төгрөгөөр

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1.1	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	199,919.0	199,294.7	624.3	99.7
1.2	80219 – Харуул хамгаалалтын зардал	13,728.0	14,352.3	(624.3)	104.5
1.3	882 –Бусад урсгал шилжүүлэг	11,264.4	11,264.4	0.00	100

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд БОАЖ-ын сайдын 2022 оны 04-р сарын 20-ны өдрийн №02 тоот албан даалгаврын дагуу сав газарт хамаарах бүх сумдын усны сан бүхий бүх газар, гол голдирлын хог цэвэрлэхэд зориулж шатахууны зардалд 500.0 мянган төгрөг олгосон гэрээ, ажлын гүйцэтгэлийн тайлан, гэрээг дүгнэсэн акт зэрэгтэй танилцлаа. Мөн Орхон Чулуут голын сав газрын захиргааны даргын 2022-12.19-ны өдрийн 112 тоот хүсэлт, Усны газрын даргын 2022.12.16-ны өдрийн А/92 тоот тушаал, БОАЖ-ын сайдын 2022.12.15-ны өдрийн 01/7300 албан тоот зэрэгт дурдагдсан 6,432.5 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авч зориулалтын дагуу 6,432.5 мянган төгрөгийг зарцуулсан байна. Бүгд нийт 6,932.5 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### • 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Орхон-Чулуут голын сав газрын захиргааны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллагаас, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагаа, бүртгэл тайлагналыг сайжруулах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Энхчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар хэрэгжүүлсэн.

Орхон Чулуут голын сав газрын захиргаа 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 15 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсөв 224,911.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,249.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 1,686.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

## 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь цалин, шимтгэлийн зардлаас бусад зардлуудаас 36.8 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгож улсын төсвийн дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

## 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Орхон-Чулуут голын сав газрын захиргаа нь тайлант хугацаанд шилэн дансанд мэдээлбэл зохих 150 мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

## 4.5. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар тус байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитын урьдчилсан болон төлөвлөх шатны ажлыг 2022 оны 12 сарын 01-нээс 2022 оны 11 сарын 18-ны хооронд хийж гүйцэтгэсэн.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	1	-	1	-	100
Зөвлөмж	1	-	1	-	100
<b>Нийт дүн</b>					<b>100</b>

2021 оны санхүүгийн тайлангаар 1 зөвлөмж, 1 албан шаардлага авсан ба биелэлтийг 2022 оны 5 сарын 27-ны өдрийн 49, 50 тоот албан тоотоор ирүүлсэн.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, нэг удаагийн тэтгэмж урамшуулал, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг анхааран авч үзэх нь зүйтэй.

Аудитаар алдаа<sup>1</sup> илрээгүй, харин залруулагдаагүй нийт 1546.7 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 1546.7 мянган төгрөгт 1 албан шаардлага хүргүүлээ.

#### 5.1 Албан шаардлага

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хичээл үйлдвэрлэлийн зардлаас Ануд ХХК-аас 689.3 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх бараа материал, шилжүүлэн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", мөн Сангийн Сайдын 2021 оны 10 сарын 02-ны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ын "210902 Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд жил бүр албан хаагчдын мэргэжлийг дээшлүүлэх, мэргэшүүлэх, давтан сургах, дадлага сургуулилт хийлгэх зорилгоор гадаад, дотоодод сургалтад хамруулахад шаардагдах сургалтын төлбөр, унаа, хоолны зардал, сургалттай холбогдсон материал бэлтгэх, багшийн хөлс төлөх, сургалтын өрөө тасалгаа, тоног төхөөрөмж түрээслэх зэрэг зардлыг энэ ангилалд бүртгэнэ." гэсэн заалтуудыг зөрчсөн байна.
2. Бусдаас гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас Өлзийтээл ХХК-аас 307.2 мянган төгрөгийн бараа материал, Ануд ХХК-аас 481.8 мянган төгрөг, Буман үсэг ХХК-аас 68.3 мянган төгрөг нийт 857.4 мянган төгрөгийг бичиг хэрэг, бага үнэтэй түргэн элэгдэх бараа материалын зардалд шилжүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", мөн Сангийн Сайдын 2021 оны 10 сарын 02-ны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ын "210902 Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд жил бүр албан хаагчдын мэргэжлийг дээшлүүлэх, мэргэшүүлэх, давтан сургах, дадлага сургуулилт хийлгэх зорилгоор гадаад, дотоодод сургалтад хамруулахад шаардагдах сургалтын төлбөр, унаа, хоолны зардал,

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

сургалттай холбогдсон материал бэлтгэх, багшийн хөлс төлөх, сургалтын өрөө тасалгаа, тоног төхөөрөмж түрээслэх зэрэг зардлыг энэ ангилалд бүртгэнэ.” гэсэн заалтуудыг зөрчсөн байна

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

Дээрх албан шаардлагын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын зарцуулалтыг авч үзэх нь зүйтэй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага Д шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орхон-Чулуут голын сав газрын захиргааны	1	1546,7	-	-	1	1546,7	-	-	-	-	-	-